



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/611

Булган сум

Хяналт шалгалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1, 11.2.2, 11.2.6, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Орхон сумын нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах МУ-020733 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ болон авто зам барих, засварлах зорилгоор түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж буй аж ахуйн нэгжүүдэд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт, Засгийн газрын 2014 оны 07 дугаар сарын 09-ний 222 дугаар тогтоолоор батлагдсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам”-ын хэрэгжилтийг шалгах, хууль бус ашигт малтмал олборлох зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсугай.

2.Хяналт шалгалтын ажлын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.


3.Хяналт шалгалтын ажлыг удирдамж, графикийн дагуу зохион байгуулж, шаардагдах хүн хүч, унаа техникээр тухай бүрд нь хангаж хамтран ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр), Орхон сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010-71

Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дугаар сарын 05-ний өдрийн А/61 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Хамтарсан хяналт шалгалт хийх ажлын удирдамж

Нэг. Шалгалтын зорилго

Байгаль орчныг хамгаалах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Зөрчлийн тухай хуулиуд мөн Засгийн газрын 222 дугаар тогтоолоор батлагдсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам” болон бусад хууль тогтоомжуудын хэрэгжилтийг шалган, илэрсэн зөрчлийг арилгаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилготой.

Хоёр. Шалгалтад хамрагдах хүрээ:

Булган аймгийн Орхон сумын нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах МУ-020733 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ болон авто зам барих, засварлах зорилгоор түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж байгаа аж ахуйн нэгжүүд хамрагдана.

Гурав. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа:

Шалгалтыг Булган аймгийн ЗДТГ-ын Геологи уул уурхай, газрын тос, хийн хяналтын улсын байцаагч Т.Наранцацралт ахлан Байгаль орчны газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч М.Хос-Эрдэнэ, Орхон сумын ЗДТГ-ын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Татварын байцаагч, Газрын даамал, Хэсгийн төлөөлөгч нар хамтран 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Хийж гүйцэтгэх ажил

4.1 Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн уурхай дээр байх ёстой баримт бичгийн бүрдэл, тухайн жилийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

4.2 Засгийн газрын 222 дугаар тогтоолоор батлагдсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам”-ын хэрэгжилтэнд хяналт тавих

4.3 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийг,

4.4 Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн хэрэгжилтийг тус тус шалгана.

Тав. Шалгалтын дүнг тайлагнах

5.1. Шалгалтаар илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг ажлын хэсгийн бүрэлдэхүүн зохион байгуулж тайлагнана.